

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 21 ДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны долдугаар сарын 03-ны өдрийн 14 цаг 07 минутад эхэлж, 14 цаг 55 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын Цөмийн технологийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Энхгэрэлийн Нямдавааг Цөмийн энергийн газрын Цөмийн технологийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, тус агентлагийн дарга Н.Тэгшбаярт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийн 2014 оны 37 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн

		<p>Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Чимэдийн Баттуяаг 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 4-т "...Миеэгомбын Батжаргал" гэснийг "...Чимэдийн Баттуяа" гэж өөрчлөх.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ч.Баттуяад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл байгуулах, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 23 дугаар тогтоолын 2-т гишүүдэд:</p> <p>"Шүүхийн сургалтын албаны дарга" гэснийг "Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн дарга" гэж;</p> <p>"Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн дарга" гэснийг "Шүүхийн захиргааны хэлтсийн дарга" гэж тус тус өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирлын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайханы 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 03/986 тоот албан бичгээр Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирлын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 2014 оны наймдугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2014 оны наймдугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
5	Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2014 оны долдугаар сарын 03-ны өдрийн ХЭГ/1252 тоот албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу уг сонгон шалгаруулалтыг 2014 оны наймдугаар сарын 04-ний өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2014 оны наймдугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
6	Бусад асуудал /Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын	Засгийн газраас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан тушаалд

	албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай танилцуулга/	томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт явуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, уг албан тушаалын нөөцийн жагсаалтад С.Буяндалай, Г.Түвшинбаяр, С.Энх-Амгалан, С.Чулуунбаатар нар бүртгэлтэй байх тул нөөцийн жагсаалтаас нэр дэвшүүлэн сул орон тоог нөхөх саналыг Засгийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ